



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн аудитын тайлан

МАЛЫН ЭМ ТАРИЛГА ВАКЦИНЖУУЛАЛТАНД ЗОРИУЛЖ УЛСЫН ТӨСВӨӨС 2016-2017 ОНД
ОЛГОСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН



МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ТӨСВӨӨС ОЛГОЖ БУЙ
ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2018

<p><u>Тайлан бэлтгэсэн:</u></p>	<p>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</p>	<p>3</p>
<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газар</p>	<p>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ</p>	<p>4-6</p>
<p>Тэргүүлэх аудитор: Д. Уламбаяр</p>	<p>БҮЛЭГ 1. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийг төлөвлөснөөс бууруулан баталсан, хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байна.</p>	<p>7</p>
<p>Аудитын менежер: Т.Байгалмаа</p>	<p>1.1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгө төлөвлөсөн хэмжээнээс бага хуваарилагдсан байна.</p>	<p>7-9</p>
<p>Ахлах аудитор: Д.Нэргүйбаатар</p>	<p>1.2. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй, 60.6 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.</p>	<p>9-12</p>
<p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ</p>	<p>БҮЛЭГ 2. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний аймгийн нэгдсэн төлөвлөгөөгүй, ихэнх вакцины үр дүнг тооцож баримтжуулаагүй байна.</p>	<p>12</p>
<p>2018 оны 09 дүгээр сар</p>	<p>2.1. Малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх аймгийн нэгдсэн төлөвлөгөөгүй байна.</p>	<p>12-13</p>
<p>Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.</p>	<p>2.2. Нийлүүлэгдсэн эм тарилга вакцин чанарын шаардлага хангасан эсэхэд Улсын МЭҮГ-н лаборатори шалгаж баталгаажуулсан байна.</p>	<p>13</p>
<p>www.audit.mn</p>	<p>2.3. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины үр дүнг үнэлж баримтжуулаагүй байна.</p>	<p>13-14</p>
<p><i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70332860 дугаарын утас, 70333141 дугаарын факсаар харилцана уу</i></p> <p>ХАЯГ:</p>	<p>ДҮГНЭЛТ</p>	<p>15</p>
<p><i>Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 311 тоот</i></p>	<p>МАЛЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ҮР ДҮН</p>	<p>16-19</p>
<p></p>	<p>ЗӨВЛӨМЖ</p>	<p>20</p>
<p></p>	<p>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ</p>	<p>21</p>
<p></p>	<p>ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ</p>	<p>22</p>

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АРА	Архангай аймаг
ГА	Гүйцэтгэлийн аудит
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
УМЭҮГ	Улсын мал эмнэлэг, үржлийн газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
МЭА	Мал эмнэлэгийн алба
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МЭҮТ	Мал эмнэлэг, үржлийн тасаг
ДХХ	Дотрын хордлогот халдвар
МЭУСАХЗ	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал
МЭУСТХ	Малын эрүүл мэнд удмын сангийн тухай хууль
ХХОАТТХ	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
МХГ	Мэргэжлийн хяналтын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Малын эм тарилга вакцинжуулалтанд зориулж улсын төсвөөс 2016-2017 онд олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн

Аудитын код: АРА-/2018/-02-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний Аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутаг дахь Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Малын эм тарилга вакцинжуулалтанд зориулж улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, орон нутгийн удирдлагад, шийдвэр гаргах түвшинд бодит мэдээллээр хангах хөрөнгийн зарцуулалтыг үр ашигтай болгох, үр дүнг дээшлүүлэх зөвлөмж, санал боловсруулж хэрэгжилтийг хангуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан эсэх
- Малыг эмчлэн сэргийлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж үр өгөөжийг бодитой тооцсон эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитаар малыг эмчлэн сэргийлэх зорилгоор улс, орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг аймгийн эрх бүхий байгууллага ХХААГазар, Мал эмнэлэг, Эрдэнэбулган, Ихтамир, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Булган сумдын мал эмнэлэг үржлийн тасаг болон үйлчилгээ үзүүлэгч хувийн мал эмнэлгүүдийн хүрээнд холбогдох гэрээ, мэдээ, тайлан, баримт материалыг түүвэрлэн шалгалаа. Мөн дээрх сумдын урьдчилан сэргийлэх тарилганд малаа хамруулсан малчдыг түүвэрлэн аудитад хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан төрийн байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, хүрсэн үр дүнг үндсэн үзүүлэлттэй харьцуулах, цуглуулсан судалгаа, шинжилгээний баримт материалд дүн шинжилгээ хийх зэргээр Тэргүүлэх Аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний аргазүйг

ашиглан аудитын хөтөлбөр горимын дагуу шаардлагатай нотлох зүйлсийг цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа..

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

- Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль 2011 он
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд
- “Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний хөлсийг шинэчлэн тогтоох тухай” аймгийн ИТХТ-ийн 2013 оны 62 дугаар тогтоол
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Үндсэн мэдээлэл

Аймгийн 19 сумын хэмжээнд 43 хувийн мал эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад жилдээ 2401-4718 мянган толгой мал хамруулсан байгаа нь тухайн онд тоологдсон нийт малын 20.7-23.4 хувийг эзэлж байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 62 дугаар тогтоолоор “Мал эмнэлгийн үйлчилгээний үнэлгээ”-г тогтоож, мал, амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсийг бод 400, бог 200 төгрөг байхаар шийдвэрлэсэн байна. Орон нутгийн төсвөөс 2015 онд хамрагдсан 2401 мянган толгой малын үйлчилгээний хөлсөнд 476.1 сая төгрөг, 2016 онд 3045 мянган толгой малын үйлчилгээний хөлс болох 484.5 сая төгрөгийг олгосон ба 2017 онд 4718 мянган толгой малын үйлчилгээний хөлсөнд улсын төсвөөс 261.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 318.5 сая төгрөгийг тус тус санхүүжүүлжээ.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Д.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Байгалмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд ахлах аудитор Д.Нэргүйбаатар, аудитор Г.Цог-Эрдэнэ нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа:

Аудитыг 2018 оны 04 сарын 23-ны өдөр эхлүүлж, 08 сарын 20-ны өдөр дуусгасан бөгөөд дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ, Засаг дарга, аймгийн ХХААГ, Мал эмнэлгийн газарт тус тус хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, аудитын зөвлөмж, хавсралт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайланд аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах бүх нотлох зүйл, мэдээллийг хангалттай зохистой хэмжээгээр оруулсан болно.

Тайлангийн төсөлд ирүүлсэн саналыг судлан үзэж аудитын тайланг эцэслэн боловсруулж аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл:

Тус аймгийн Хашаат, Өгийнуур, Батцэнгэл, Хотонт, Төвшрүүлэх, Цэнхэр зэрэг 6 суманд малын гоц халдварт шүлхий өвчин гарсны улмаас илрүүлэлтийн талаарх хэлэлцүүлэг, аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулан саналыг авахаар төлөвлөсөн хугацаа хэрэгжээгүй болно. Мөн багийн гишүүд 2018.07.16-наас 2018.08.13-ний өдрийг хүртэл ээлжийн амралттай байсан.

Дээрхи асуудлаас шалтгаалан аудитын тайлангийн төслийг 2018 оны 08 дугаар сарын 20-ны өдөр албан бичгээр аймгийн ХХААГ-т хүргүүлэн, 2018 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр аймгийн ХХААГ-аас тайланд өгөх санал албан бичгээр ирсэн болно.

БҮЛЭГ-1


МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙГ ТӨЛӨВЛӨСНӨӨС БУУРУУЛАН БАТАЛСАН, ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1 МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГИЙГ ТӨЛӨВЛӨСӨН ХЭМЖЭЭНЭЭС БУУРУУЛАН БАТАЛСАН БАЙНА.

1.1.1 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах төсвийн саналыг хүргүүлсэн хэмжээнээс 7.9-17.2 хувиар бууруулан баталж байна.

Эпизотологийн зураглал, өвчлөлийн бүртгэлд үндэслэн Архангай аймгийн 2016 онд халдварт өвчнөөс сэргийлэх 13 арга хэмжээнд нийт 2720 мянган толгой мал амьтад хамруулж 9938 литр био тарилга, 1240 мянган тун хатаасан бэлдмэл зарцуулахад нийт 927.4 сая төгрөгийн, 2017 онд мөн 13 арга хэмжээнд 1341 мянган толгой мал хамруулж 8458 литр тарилга, 120 мянган тун хатаасан бэлдмэл зарцуулах, нийт 579.4 сая төгрөгийг үйлчилгээний хөлсөнд олгохоор тус тус тооцож аймгийн Засаг даргаар батлуулан улсын МЭҮГ-т хүргүүлжээ. Гэтэл хүргүүлсэн захиалгаас боом, сахуу, ДХХ, Цусан халдвартаас сэргийлэхэд хамрагдах мал, шаардагдах тарилгын хэмжээг МЭҮГ-аас бууруулан батлуулж ирүүлсэн байна. дэлгэрэнгүй Хавсралт 1-ээс үзнэ үү.

Аймгийн хэмжээгээр нэгтгэж улсын МЭҮГ-т хүргүүлсэн вакцинд хамрагдах нийт малын тооны саналыг батлагдсан хэмжээтэй нь харьцуулж графикаар харуулбал: / мянган толгойгоор/



Эх сурвалж: аймгийн ХХААГ-ын МЭА-ны 2016, 2017 оны жилийн эцсийн мэдээ, ХХААГ-т хүргүүлсэн албан бичиг

Дээрх графикаас харвал халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхээр төлөвлөж аймгийн хэмжээний нэгтгэсэн малын тоог 2016 онд 17.2 хувиар, 2017 онд 7.9 хувиар тус тус бууруулан баталж түүнд ногдох вакциныг улсын МЭҮГ-аас нийлүүлсэн байна.

1.1.2 Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулдаг ч гэрээг дүгнэж, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Улсын МЭҮГ-аас батлагдсан хэмжээг үндэслэн аймгийн ХХААГазраас үйлчилгээ үзүүлэгч мал эмнэлэгүүдтэй гэрээ байгуулан урьдчилан сэргийлэх тарилга, вакцинжуулалтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Тухайлбал: 2016 онд нийт 43, 2017 онд 45 хувийн хэвшлийн мал эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгүүлжээ. /Дэлгэрэнгүйг Хавсралт №2-оос үзнэ үү/

Гэвч мал эмнэлгүүдтэй байгуулсан энэхүү хамтран ажиллах гэрээг дүгнэж хэрхэн ажилласныг дүгнэсэн нотлох баримтгүй байна.

1.1.3 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд вакцинжуулахаар төлөвлөсөн малыг бүрэн хамруулж чадаагүй байна.

Төсөв хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас хамаараад аймгийн хэмжээний нийт малыг хамруулах боломжгүй байна.

Харин Эпизотологийн зураглал, өвчлөлийн бүртгэлд үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо, шаардагдах зардлыг төлөвлөн аймгийн Засаг даргаар батлуулж улсын МЭҮГ-т хүргүүлдэг /дэлгэрэнгүйг 1.1.1-д тусгасан/ боловч төлөвлөсөн хэмжээгээр тарилга, вакциныг нийлүүлдэггүй байна. Үүний улмаас аймгийн хэмжээнд тухайн жилд урьдчилсан сэргийлэх тарилгад хамруулахаар төлөвлөсөн малыг бүрэн хамруулж чадахгүй байна. Тухайлбал: 2016 онд улсын МЭҮГ-т хүргүүлсэн захиалгын тоог бод 13%, бог 18.2%-иар бууруулж баталсан байна. Дэлгэрэнгүйг төлөвлөгөө, гүйцэтгэлийн харьцуулсан судалгаа Хавсралт №3-аас үзнэ үү.

Архангай аймгийн сумдын 2016, 2017 онд мал амьтны урьдчилан сэргийлэх тарилгад хамруулахаар төлөвлөсөн малын тоо, нийт малын тоонд эзлэх хувь

Хүснэгт №1

№	Сумын нэр	2016 он			2017 он		
		Вакцинд хамрагдах нийт малын тоо	Сумын нийт малын тоо	Вакцинд хамрагдах малын эзлэх %	Вакцинд хамрагдах нийт малын тоо	Сумын нийт малын тоо	Вакцинд хамрагдах малын эзлэх %
1	Хотонт	78.4	316	24.8	74	336.8	22.0
2	Ихтамир	96.2	338.7	28.4	91	358.5	25.4
3	Чулуут	50	187.5	26.7	45	194.9	23.1
4	Хангай	35	96.8	36.2	33	109.5	30.1
5	Тариат	54	239.2	22.6	50	265.3	18.8
6	Цэцэрлэг	71.5	319	22.4	68.4	322.6	21.2
7	Батцэнгэл	94.1	372.5	25.3	92	401.3	22.9
8	Өгийнуур	55.9	282.6	19.8	55	304.3	18.1
9	Цэнхэр	51.2	297.5	17.2	53	316.6	16.7
10	Эрдэнэмандал	105.2	473.6	22.2	99	488.7	20.3

11	Өндөр-Улаан	80	328.2	24.4	77	348.4	22.1
12	Цахир	33	94.1	35.1	27	111.2	24.3
13	Эрдэнэбулган	61.8	195.4	31.6	48	200.2	24.0
14	Хайрхан	67	326.9	20.5	63	372.7	16.9
15	Хашаат	61.3	328.1	18.7	57.4	341.2	16.8
16	Төвшрүүлэх	30.8	135.3	22.8	31	155.3	20.0
17	Булган	25.7	112.9	22.8	26	133	19.5
18	Жаргалант	64.3	273.7	23.5	60	239.7	25.0
19	Өлзийт	53.9	282.6	19.1	49.6	304.3	16.3
Аймгийн дүн		1169.3	5000.6	23.4	1099.4	5304.5	20.7

Эх сурвалж: аймгийн Статистикийн хэлтсийн гаргасан малын тоон динамик, ХХААГ-ын даргын Мал эмнэлэгүүдтэй байгуулсан гэрээ

Дээрх хүснэгтээс /Хүснэгт №1/-ээс харвал аймгийн хэмжээний нийт малын 20.7-23.4 хувь /2016 онд 23.4 %, 2017 онд 20.7 хувь/-ийг тус тус халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамруулсан байна.

1.2. МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР ТӨСВӨӨС ОЛГОСОН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС 76.4 САЯ ТӨГРӨГИЙН АНХАН ШАТНЫ БАРИМТЫН БҮРДЭЛ ДУТУУ БАЙНА.

1.2.1 Улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтаас 76.4 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.

УМЭГ-ын даргын 2015 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/21 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар 2015 оны Бруцеллёзын вакцинжуулалтад зориулж 160,388.3 мянган төгрөгийг, 2016 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн а/35 дугаарт тушаалын 1 дүгээр хавсралтаар 2016 оны Бруцеллёзын вакцинжуулалтад зориулж 166,564.9 мянган төгрөгийг, 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн а/30 дугаарт тушаалын 1 дүгээр хавсралтаар 2017 оны Бруцеллёзын вакцинжуулалтад зориулж 197,615.5 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар баталжээ.

Батлагдсан төсвийг үндэслэн аймгийн ХХААГ-аас малын тоо, халдварт өвчний бүртгэл эпизотологийн зураглал, өвчлөл гарах эрсдэл зэргийг тооцон сумдын мал эмнэлгүүдэд дахин төсвийн хуваарилалтыг хийж газрын даргаар батлуулан, сумдын Засаг дарга, мал эмнэлгүүдтэй гурвалсан гэрээ байгуулан баталгаажуулсан байна.

Харин 2017 онд Архангай аймагт гоц халдварт хонины цэцэг өвчин гарсан тул голомт болон ойролцоох сумдыг голомт руу хумих байдлаар вакцинд хамруулах арга хэмжээ авч түүнд 385.8 сая төгрөгийн тарилгын хөлсийг улсын төсвөөс олгосон байна.

Улс, төсвөөс МЭУСАХЗардлыг батлагдсан төсөв, санхүүжилт, гүйцэтгэлийг харьцуулсан байдлаар харуулбал:

Хүснэгт №2

/сая.төг/

№	МЭУСА Хэмжээ /төрөл/	2015 он			үлдэ гдэл	2016 он			үлдэ гдэл	2017 он			үлдэ гдэл
		Батла гдсан төсөв	Санхү үжилт	Гүйцэ тгэл		Батла гдсан төсөв	Санхү үжилт	Гүйцэ тгэл		Батла гдсан төсөв	Санхү үжилт	Гүйцэ тгэл	
1	Бруцелл ёз	160.4	153.9	152.7	1.2	166.5	166.5	166.5	-	197.6	199.4	199.4	-
2	Хонины цэцэг	-	-	-	-	-	-	-	-	385.8	385.8	385.8	-
3	Шүлхий тандалт									1.7	1.7	1.7	
НИЙТ ДҮН		160.4	153.9	152.7	1.2	166.5	166.5	166.5	-	585.1	586.9	586.9	-

Улсын төсвөөс 2016 онд олгосон нийт 320.5 сая төгрөг /2015 оны үлдэгдэл 154.0 сая төгрөг оруулаад/-ийн бруцеллёзын тарилгын хөлсийг анхан шатны баримтаар тулган шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу өөр хэлбэл сумын МЭҮТ-ийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, сумын Засаг даргын Зөвлөлийн хурлын шийдвэр мөн сумын Засаг даргын тодорхойлолт албан бичиг зэргийг бүрдүүлсэн байх гэсэн шалгуур үзүүлэлтийг хангаагүй 10 ажил гүйлгээгээр 38.6 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Орон нутгийн төсвөөс гоц халдварт өвчнөөр өвчилж зайлшгүй шаардлагаар устгасан малын нөхөн төлбөрт 2016 онд цэцэг өвчний улмаас устгасан 3203 толгой хонины нөхөн төлбөрт 212.4 сая төгрөг, 2017 онд мялзан өвчний улмаас устгасан 401 толгой хуц, ухнын нөхөн төлбөрт 28.9 сая төгрөгийг МЭУСТХуулийн 15.1.4 дэх заалтын дагуу МУЗГ-ын тогтоол, АЗД-н захирамжаар малчдад олгосон байна.

Харин 2017 онд цэцэг, бруцеллөз өвчний тарилгын хөлснөөс Өгийнуур сумын Баянбургатай Мал эмнэлэг нь үйл ажиллагаагаа зогсоосон учраас аймгийн МЭА, Өгийнуур сумын бага эмч нар хамтран тарилга хийсэн гэж аймгийн МЭА-ны дарга С.Ганбат нь малын их эмч Ө.Сэр-одын хувийн харилцах дансанд 24.5 сая төгрөг, П.Будхүүгийн хувийн харилцах дансанд 19.7 сая төгрөг нийт 44.2 сая төгрөгийг гаргуулан авсан бөгөөд малын эмч нарт тарилгын хөлсийг олгосон 22.0 сая төгрөгийн баримтыг аудитын явцад бүрдүүлэн шалгуулсан болно.

Мөн 2017 оны 06 дугаар сард Хашаат, Өгийнуур суманд хонины цэцэг өвчний тарилга хийсэн нэр бүхий 32 малын эмчид 37.8 сая төгрөгийн тарилгын хөлсийг олгохдоо албан татварын дундын суутгал хийж төсөвт шилжүүлээгүй ХХОАТТХуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна.

Иймд дээрх зөрчлүүдийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх, баримтын бүрдлийг хангаж эргэж шалгуулах хугацаатай албан шаардлагыг аймгийн ХХААГ-т, албан татвар суутган авч шилжүүлээгүй асуудлыг аймгийн Татварын хэлтэст шилжүүлэн шалгуулж холбогдох арга хэмжээг авахуулахаар шийдвэрлэлээ.

1.2.2 Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн а/184 дугаарт захирамжийн хавсралтаар орон нутгийн төсвөөс мал эмнэлгийн тарилгын үйлчилгээний

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

хөлсөнд 493.4 сая төгрөгийг, мөн аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн а/81 дугаар захирамжийн хавсралтаар орон нутгийн төсвөөс мал эмнэлгийн тарилгын үйлчилгээний хөлсөнд 480.8 сая төгрөг, халдварт өвчний шинжилгээ хийхэд 7.7 сая төгрөгийг зарцуулахаар тус тус баталжээ.

Орон нутгийн төсвөөс мал эмнэлгийн тарилгын үйлчилгээний хөлсийн батлагдсан төсөв, санхүүжилт, гүйцэтгэлийг харьцуулсан байдлаар харуулбал:

Хүснэгт №3

/сая.төг/

№	МЭУСАХэмжээ /төрөл/	2016 он			үлдэгдэл	2017 он			үлдэгдэл
		Батлагдсан төсөв	Санхүүжилт	Гүйцэтгэл		Батлагдсан төсөв	Санхүүжилт	Гүйцэтгэл	
1	Тарилгын үйлчилгээний хөлс	493.5	492.3	491.6	0.7	488.5	483.5	483.5	-
НИЙТ ДҮН		493.5	492.3	491.6	0.7	-	-	-	-

Аудитаар сумдын мал эмнэлгүүдийг түүвэрлэн шалгахад малын “А” дансны бүртгэл болон малчин өрхийн малын эрүүл мэндийн дэвтрийн бичилтээс илүү тооны малыг тарьсанаар тарилгын цуваанд бүртгэж Цэцэрлэг сумын Туулант багийг хариуцсан Цэнгэгнуур мал эмнэлэг 65,200 төгрөгийн, Ихбулаг багийг хариуцсан Биоген мал эмнэлэг 163,200 төгрөгийн, Хонгорж багийг хариуцсан Ар-Ундрам мал эмнэлэг 248,000 төгрөгийн нийт 476,200 төгрөгийн санхүүжилтийг илүү авсан зөрчил илэрлээ.

Илүү авсан санхүүжилт болох 476200 төгрөгийн төлбөрийг дээрх мал эмнэлгүүдээс гаргуулан 2018 оны 09 дүгээр сарын 20-ны дотор аймгийн орон нутгийн төсвийн орлогын Төрийн сан банкин дахь 100010000914 тоот дансанд төвлөрүүлэхээр акт тогтоолоо.

Мөн Ихтамир, Эрдэнэмандал сумын зарим багт Содон сүрэг, Хэншиг зэрэг мал эмнэлгүүд нь тарилга үйлчилгээ хийдэг бөгөөд эдгээр мал эмнэлгүүд нь тухайн суманд байрладаггүйгээс малчдаас дуудлага өгсөн үед ирдэггүй, малчдын сууриар эргэдэггүй зэрэг гомдлыг малчид гаргаж байлаа.

1.2.3 Батлагдсан санхүүжилтийг үнэн зөв тайлагнасан байна.

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын үйлчилгээний хөлсөнд улс, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №4

/сая төгрөг/

Он	Улсын төсөв		Орон нутгийн төсөв	
	Олгосон санхүүжилт	Гүйцэтгэл тайлангаар	Олгосон санхүүжилт	Гүйцэтгэл тайлангаар
2016	166.5	166.5	492.3	491.6
2017	586.9	586.9	483.5	483.5
Нийт дүн	753.4	753.4	975.8	975.1

Санхүүжилтийн зарцуулалт үр ашигтай холбоотой асуудлыг нэгдүгээр бүлгийн 1.2-т тусгасан тул дэлгэрэнгүйг дээрээс үзнэ үү. Дээрх бүлэг 1-ийн 1.2.1, 1.2.2-т дурдсан нийт 98.3 сая төгрөгийн зөрчлийг эс тооцвол санхүүжилтийг үнэн зөв тайлагнасан байна.

БҮЛЭГ- 2

МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЙМГИЙН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨГҮЙ, ИХЭНХ ВАКЦИНЫ ҮР ДҮНГ ТООЦОЖ БАРИМТЖУУЛААГҮЙ БАЙНА.

2.1. МАЛЫГ ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨГҮЙ БАЙНА.

2.1.1 Мал эмнэлэгийн үйлчилгээг хэрэгжүүлэгч байгууллагууд жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, үр дүнг тайлагнах арга хэмжээ хангалтгүй байна.

Аудитад хамрагдсан мал эмнэлэгүүд нь аймгийн ХХААГ болон сумын засаг даргатай байгуулсан гэрээгээр үзүүлэх үйлчилгээг жилийн төлөвлөгөө гэж үзэж байгаа бөгөөд хэрэгжилт, үр дүнгийн талаар тусгай тайлан гаргадаггүй, зөвхөн мал эмнэлгийн албанд гаргаж өгдөг хугацаатай мэдээнүүд, тарилгын үйчилгээний хөлс авахын тулд сумын Засаг даргын зөвлөлд хийдэг мэдээлэл, тарилга хийсэн акт, тарилгын цуваагаар жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээ, тайланг хязгаарласан байна. Энэ нь Малын удмын сан, эрүүл мэндийг тухай хуулийн 6.1.1¹, 6.4²дэх заалтыг хэрэгжүүлээгүй гэж үзэхэд хүргэж байна.

2.1.2 Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх аймгийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж батлаагүй байна.

Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох тухай аймгийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж батлуулаагүй байна. Аймгийн ХХААГ-ын Мал эмнэлэгийн жилийн төлөвлөгөөнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг нийт дүнгээр тусгаж төлөвлөсөн. Аймгийн Засаг даргын ХХААХҮСайдтай байгуулсан үр дүнгийн гэрээний 26-д "...эрсдэл бүхий өвчнөөс эрүүлжүүлэх, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан, батлан мөрдөх..." заалтыг хэрэгжүүлээгүй байлаа. Өөрөөр хэлбэл халдварт өвчин тус бүрээр урьдчилан сэргийлэх арга хэмжээний аймгийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж баталж мөрдөөгүй буюу Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.5.3³ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. /2018.06.01-нийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөж байсан/

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний аймгийн нэгдсэн төлөвлөгөө байхгүй учир үр дүнг нэгтгэн тооцож үнэлээгүй байна.

2.2. НИЙЛҮҮЛЭГДСЭН ЭМ ТАРИЛГА, ВАКЦИН ЧАНАРЫН ШААРДЛАГА ХАНГАСАН ЭСЭХИЙГ УЛСЫН МЭҮГ-ЫН ЛАБОРИТОРИ ШАЛГАЖ БАТАЛГААЖУУЛСАН БАЙНА.

¹малын өвчинтэй тэмцэх, сэргийлэх болон үржлийн ажлын талаар жил бүр авах арга хэмжээг төлөвлөх, төсөл боловсруулах, захиалга хэрэгжүүлэх, анхан шатны мэдээ тайлан, акт баримтыг зааврын дагуу үнэн зөв хөтлөх;

² Орон нутгийн үйлчилгээний нэгж нь энэ хуулийн 6.1-д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

³ энэ хуулийн 15.1.2-т заасан өвчнөөс урьдчилан сэргийлэх болон 6.4.4, 6.4.5-д заасан арга хэмжээнд хамруулах малын төрөл, тоо, шаардагдах зардлыг нэгтгэн төлөвлөх, энэ заалтад заасан арга хэмжээг орон нутгийн үйлчилгээний нэгж, албадтай гэрээ байгуулж хэрэгжүүлэх;

2.2.1. Улсын төсвөөс нийлүүлэгдсэн эм тарилгын чанар, стандартыг баталгаажуулсан эсэхийг шалгаж хүлээн авчээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг МЭҮГ-ын мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийн баталгаажуулалтын албаны экспертийн дүгнэлтээр баталгаажуулсан вакциныг аймгийн ХХААГ-ын мал эмнэлгийн албанд нийлүүлдэг бөгөөд вакциныг хүлээн авахдаа дүгнэлтийг тулган хүлээж авдаг тухай тайлбарыг ирүүлсэн болно. 2016, 2017 онуудад нийлүүлэгдсэн вакцины экспертийн дүгнэлтүүд нийт 157 хуудас материалтай танилцсан болно.

2.2.2. Тарилгын явцад хүндрэл гарч мал хорогдоогүй байна.

Аудитад хамрагдсан үйлчилгээ үзүүлэгч мал эмнэлгүүдэд болон аймгийн МЭА-д вакцины тарилгын явцад хүндрэл гарч мал хорогдсон талаар бүртгэгдээгүй. Малчдаас авсан санал асуулгын явцад зарим малчид вакцины дараа мал хорогдсон гэх боловч малын эмчийн акт гаргуулаагүй, тэмдэглүүлээгүй учир нотлох баримтгүй байна.

2.2.3. Мал эмнэлэг, малчдаас эм, тарилгын талаар гомдол гараагүй байна.

Мал эмнэлгийн зүгээс аймгийн Мал эмнэлгийн албанд ямар нэгэн гомдол мэдээлэл ирүүлээгүй мөн мал эмнэлгүүдэд малчдаас гомдол гаргаж ирүүлээгүй байна.

2.3. МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЖ БАРИМТЖУУЛААГҮЙ БАЙНА.

2.3.1. Бруцеллёзоос өөр вакциныг тарилга хийсний дараа дархлаа тогтсон эсэхийг шалгаж баримтжуулаагүй байна.

Аудитад 6 сумын 279 малчинг санамсаргүй түүврийн аргаар сонгож вакцинд хамрагдсан байдлыг тулган шалгасан бөгөөд вакцины дараа дархлаа тогтсон эсэхийг шалгасан талаар асуулгын хуудсаар лавлахад бүгд аваагүй гэсэн хариулт өгсөн болно. Аймгийн ХХААГ-ын МЭА-наас ирүүлсэн баримтаар бруцеллез өвчний вакцины идэвхийг шалгах шинжилгээг 2016 онд Тариат сумын 45 өрхийн 675 дээжийг шинжилж 64.4 % идэвхтэй, 2017 онд 5 сумын 162 өрхийн малаас 1632 дээж авч шинжлэхэд 80.0 % идэвхтэй гэж үр дүнг нэгтгэж дүгнэсэн байна. Эх сурвалж: аймгийн МЭА-ны лабораторийн эрхлэгчийн ирүүлсэн дүн

Харин бусад халдварт өвчний вакцины идэвхийг шалгах шинжилгээг хийж баримтжуулдаггүй байна.

2.3.2. Тарилга, вакцинжуулалт хийснээр өвчлөл өмнөх онуудаас буураагүй байна.

Аймгийн Мал эмнэлгийн албаны ирүүлсэн халдварт өвчний бүртгэлийн мэдээнээс харахад галзуу, сальмёлез, шөвөг яр, листорез, дуут хавдар гэсэн өвчин өмнөх онуудаас 5 хувиас 5 дахин өссөн бол колибактериоз, дотрын халдварт хордлого, цусан халдварт үхрийн хорт салст халуурал өмнөхөөс буурсан үзүүлэлттэй байна. Дээрх бүртгэлээс харахад манай аймагт Галзуу, колибактериоз, ДХХ, цусан халдвар өвчнүүд жил дараалан болон 2-3 жилийн дараа гарч мал амьтан өвчилсөн байна. Халдварт өвчний гаралтыг сумаар авч үзвэл Төвшрүүлэх суманд 7 төрлийн халдварт өвчин гарч бүртгэгдсэн нь хамгийн их байгаа бол Жаргалант, Хотонт, Ихтамир суманд тус бүр 6, Цэнхэр, Батцэнгэл, Өгийнуур суманд тус бүр

5, Хашаат, Чулуут, Цэцэрлэг, Хайрхан, Эрдэнэмандал суманд тус бүр 4, Хайрхан, Өлзийт, Эрдэнэбулган, Өндөр-улаан суманд тус бүр 3, Булган, Тариат суманд тус бүр 2, Цахир суманд 1 төрлийн халдварт өвчин бүртгэгдсэн байна. Эдгээрээс Тариат, Хангай, Цахир, Өндөр-Улаан сумаас бусад 15 суманд 1-3 төрлийн халдварт өвчин жил дараалан болон 2-3 жилийн давтамжтай гарчээ. Тухайлбал: бог малын ДХХ 14 суманд жил дараалан гарсан, цусан халдварт 7 суманд, галзуу 3 суманд, колибактериоз 4 суманд тус тус жил дараалан гарсан байна.

Аудитад хамрагдсан малчдаас авсан асуулгаар вакцинд хамрагдсан мал уг халдварт өвчнөөр өвчлөөгүй гэсэн боловч халдварт өвчин тухайн суманд жил дараалан болон давтамжтай гарч байгаа нь бүх малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, вакцинд бүрэн хамруулах шаардлагатай болохыг харуулж байна.

2.3.3. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар тухайн жилийн төлөвлөсөн үр дүн хангагдаагүй байна.

Аймгийн Засаг Даргын мөрийн хөтөлбөрийн 1.2.6-д "Мал эмчилгээний төвийг байгуулж, мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг ханган, мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авч эрүүл малтай аймаг болох арга хэмжээг хэрэгжүүлнэ" гэж тусгасан боловч малын халдварт өвчин гарсаар байгаа нь үр дүнтэй хэрэгжээгүй гэж үзэхэд хүргэж байна.

Аймгийн ХХААГ-ын МЭА-аас тухайн жилийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай малын тоо, вакцины хэмжээг нэгтгэн улсын МЭҮГ-т хүргүүлж байгаа боловч МЭҮГ-аас дээрх захиалгын тоог бууруулан баталж вакциныг нийлүүлж байна. Харин МЭҮГ-аас ирүүлсэн вакцины хэмжээгээр мал, амьтныг урьдчилан сэргийлэх тарилгад хамруулж байгаа боловч аймгийн хэмжээнд халдварт өвчнүүд их бага хэмжээгээр гарсаар байгаа нь урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөсөн үр дүн бүрэн хангагдаагүй гэж үзэхэд хүргэж байна.

-----000-----

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгийг төлөвлөсөн хэмжээнээс бууруулан баталсан байна.
- Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулдаг ч гэрээг дүгнэж, үр дүнг тооцож ажиллаагүй байна.
- Төсвийн санхүүжилтийн зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байна.
- Малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны аймгийн нэгдсэн төлөвлөгөөгүй байна.
- Нийлүүлэгдсэн эм тарилга, вакцин чанарын шаардлага хангасан эсэхийг улсын МЭҮГ-ын лаборатори шалгаж баталгаажуулсан байна.
- Малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бруцеллёзоос бусад вакцины үр дүнг үнэлж баримтжуулаагүй байна.
- Малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухайн жилийн төлөвлөгөө үр дүнтэй хэрэгжээгүй, зарим өвчний гаралт буураагүй байна.

Дээрх дүгнэлтүүдийг нэгтгэн дараах ерөнхий дүгнэлтийг өглөө.

МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ТӨСВӨӨС ОЛГОЖ БУЙ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Аудитын явцад нийт 115.4 сая төгрөгийн зөрчил төлбөр илэрснээс 0.5 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоон, 114.9 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлагыг аймгийн ХХААГ, МХГ-т хүргүүллээ.

Мөн албан татварын дундын суутгал хийхгүйгээр иргэдэд 37.2 сая төгрөгийн үйлчилгээний хөлс олгосон зөрчлийг албан татварыг нөхөн төлүүлэх, холбогдох шийдвэр гаргуулж арга хэмжээ авахуулахаар аймгийн Татварын хэлтэст шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэлээ.

Аудитын тайлан боловсруулсан:

Аудитор
Ахлах аудитор

Г.Цог-Эрдэнэ
Д.Нэргүйбаатар

Хянасан:

Аудитын менежер
Тэргүүлэх аудитор

Т.Байгалмаа
Д.Уламбаяр

2018.09.04

МАЛЧДААС АВСАН САНАЛ АСУУЛГЫН ҮР ДҮН


Малын эм тарилга вакцинжуулалтанд зориулж улсын төсвөөс 2016-2017 онд олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын хүрээнд Жаргалант, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Өндөр-Улаан, Ихтамир, Булган, Эрдэнэбулган сумдын хэмжээнд 279 малчин өрхөөс санал асуулга авч нэгтгэлээ. Санал асуулгын зорилго нь сумдын мал эмнэлэгээс үзүүлж байгаа үйлчилгээ малчдад үр дүнтэй хүрч байгаа эсэх мөн цаашид авч хэрэгжүүлэх анхаарах асуудлын талаар удирдлагын түвшинд дүгнэлт зөвлөмж өгөхөд оршиж байгаа болно.

Санал асуулга-1. /График-1/




Улсын төсвөөс үнэ төлбөргүй хийж буй малын халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эм тарилга, вакцинжуулалтанд хамруулсан уу? гэсэн асуултад 264 малчин буюу 94.6% нь зарим хэсгийг хамруулсан гэж хариулсан нь мал сүргийг бүрэн урьдчилан сэргийлэх эм, тарилгад хамруулж чадахгүй байгааг харуулж байна.

Санал асуулга-2. /График-2/



Малын эмч нар малын эрүүл мэндийн дэвтэрт тарилгад хамрагдсан тухай бүр тэмдэглэж байна уу? гэсэн асуултад 74.9 % буюу 209 малчин тэмдэглээгүй гэж хариулсан нь малын эмч нар малчин өрхийн эрүүл мэндийн дэвтэрийн хөтлөлтийг хангалтгүй хийж байгааг харуулж байна.


Санал асуулга-3. /График-3/



Хамрагдаагүй бол ямар вакцинд хамрагдаагүй вэ? Гэсэн асуултад 249 малчид Дуут хавдар, 235 малчид Сахуу, 230 малчид Галзуу, 216 малчид Шөвөг яр гэж хариулсан нь урьдчилан сэргийлэх вакцины хүртээмж хангалтгүй байгааг харуулж байна.

Вакцинд хамрагдаагүй шалтгааныг малчдаас тодруулахад нийт 279 малчдын 70.6% буюу 197 малчид вакцины хүрэлцээ дутмагаас гэсэн хариултыг өгсөн байна.

Санал асуулга-4. /График-4/



Танай вакцинд хамрагдсан малаас өвчилсөн тохиолдол гарсан уу? гэсэн асуултад 269 малчид гараагүй гэж хариулсан нь урьдчилан сэргийлэх вакцинжуулалт үр дүнтэй байгааг харуулж байна.

10 малчин гарсан гэж хариулсан ба шалтгааныг тулгахад ДХХ-аар жил бүр өвчлөл гарч мал хорогддог гэж хариулсан байна.

Иймд жил бүр ДХХ-ын вакциныг бүх малыг хамруулан урьдчилан сэргийлэх тарилга хийх шаардлагатай байгааг харуулж байна.

Санал асуулга-5. /График-5/




Вакцин чанарын шаардлага хангаж байна уу? гэсэн асуултад 260 малчид хангадаг гэж хариулсан нь урьдчилан сэргийлэх вакцин чанарын шаардлага хангаж байна гэж үзэхээр байна.

Санал асуулга-6. /График-6/



Урьдчилан сэргийлэх эм тарилга, вакцинжуулалтын хөлсийг малын эмчид төлдөг үү? Гэсэн асуултад 257 малчид огт төлбөр төлдөггүй гэж хариулсан нь хувийн мал эмнэлгүүд нь малчдаас үйлчилгээний хөлс авдаггүйг харуулж байна.

Санал асуулга-7. /График-7/



Вакцин хийснээс хойш танай сумын малаас тархлаа тогтсон эсэхийг шалгаж шинжилгээ авсан уу? гэсэн асуултад 267 малчид аваагүй гэж хариулсан нь аймгийн Мал эмнэлгийн албанаас тархлаа тогтсон эсэхийг шалгах шинжилгээг хангалтгүй авсанг харуулж байна.

Санал асуулга-8. /График-8/



Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсанаар халдварт өвчин гарах нь буурсан уу? гэсэн асуултад 147 малчид бага зэрэг буурсан, 124 малчид үлэмж буурсан гэж хариулсан нь урьдчилан сэргийлэх вакцинжуулалт үр дүнтэй хэрэгжсэн гэж үзэхэд хүргэж байна.

Санал асуулга-9.

№	Малчдын өгсөн санал	Иргэдийн санал хүсэлтийн тоо /давхардсан тоогоор/	Үүнийг хувиар харуулбал:
1	МЭМД-тэй болох	172	50.3%
2	ДХХ-ын вакцинд бүрэн хамрагдах	25	7.3%
3	Вакциныг цаг хугацаанд нь тарьж байх	53	15.5%
4	ЦХ-ын вакцинд малаа бүрэн хамруулах	2	0.6%
5	Шөвөг ярын вакцинд малаа бүрэн хамруулах	4	1.2%
6	Вакциныг бүх малд хийхээр хүрэлцээтэй болгох	39	11.4%
7	Мал эмнэлэгийн үйлчилгээг сайжруулах	42	12.3%
8	Баг тус бүрт малын эмчтэй болох	5	1.5%
Нийт дүн		342	100%

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мал эмнэлгийн үйлчилгээний цаашид авах арга хэмжээний талаар малчдын өгсөн саналыг нэгтгэхэд 172 малчин буюу 50.3% нь Малын өрхийн эрүүл мэндийн дэвтэртэй болох гэж , 53 малчин буюу 15.5% нь вакциныг цаг хугацаанд нь тарьж байх гэж, 42 малчин буюу 12.3 % нь мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах гэсэн нь хамгийн их санал байлаа.

Малчдаас авсан санал асуулгын дүнг нэгтгэн дүгнэвэл:

Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд мал, амьтдыг бүрэн хамруулах, малд чын өрхийн эрүүл мэндийн дэвтрийн бичилтийг сайжруулах, тархлаа тогтсон шинжилгээг тогтмол авч хэвших шаардлагатай байгааг харуулж байна.

Санал асуулгын дүнд үндэслэн холбогдох арга хэмжээ авахыг аудитын зөвлөмжинд оруулж аймгийн ХХААГ-ын даргад хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

-----000-----

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг аймгийн

Засаг дарга Ц.Мөнхнасан, ХХААГ-ын дарга П.Гомбодорж нарт хүргүүлж байна.

Аймгийн Засаг дарга Ц.Мөнхнасанд

1. Аймгийн хэмжээнд малын халдварт өвчний судалгаа шинжилгээг эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран хийж өвчнийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх
2. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх аймгийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах
3. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины тархлаа тогтсон эсэхийг шалгаж шинжилгээ хийх хөрөнгийг тооцож төлөвлөн аймгийн ИТХ-аар батлуулах, хэрэгжилтийг хангуулах

Аймгийн ХХААГ-ын дарга П.Гомбодоржид

1. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины тарилгын хөлс олгох журмыг боловсруулан баталж мөрдүүлэх
2. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдтэй байгуулсан хамтран ажиллах гэрээг хагас бүтэн жилээр дүгнэж, үр дүнг тооцож ажиллах
3. Аймгийн хэмжээнд малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг жил бүр батлуулж, хэрэгжилтийг тайлагнаж хэвших
4. Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт хийгдсэний дараа тарилгад хамрагдсан малын 10-20 хувьд дархлаа тогтсон эсэхийг шалгаж баримтжуулж хэвших
5. “Малчин өрхийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг бүх малчин өрхөд олгож, дэвтэрт хөтлөлт заавал хийж хэвшүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тавих хяналтыг сайжруулах

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Урагтэй бэлтгэж!
Ариун шударга!

АРХАНГАЙ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

65139 Архангай аймаг, Эрдэнэбулган сум
Утас/факс: (976) 7033-3889
Э-мэйл: ar.mofa@yahoo.com

2018.09.05 № 11/486
Танай 2018.07.04-ны № 174 -Т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөний дагуу малын эм тарилга, вакцинжуулалтад улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Ирүүлсэн тайлантай холбогдуулан манай байгууллагын удирдлага, вакцинжуулалтад ажилласан малын эмч нар та бүхэнтэй уулзаж санал солилцон холбогдох тайлбарыг өгч анхан шатны зарим баримтуудын бүрдлийг хангаж нэгдсэн ойлголцолд хүрсэн тул нэмэлт санал байхгүй болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *П. Гомбодорж* П.ГОМБОДОРЖ

My.docx blank-A5

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2018 оны 09 сарын 05 өдөр Дугаар 1/25

Цэцэрлэг

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1 дэх заалт, 2016 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2018 оны 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Малын эм тарилга, вакцинжуулалтанд зориулж улсын төсвөөс 2016-2017 онд олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнд"-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр байршуулан аймгийн ИТХ, Засаг даргад болон аймгийн ХХААГ, Мал эмнэлгийн газарт хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор /Д.Нэргүйбаатар/-т даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ДУЛАМБЯАР





Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Зөрүүлэх аудитори 2018 оны 02 сарын 02 өдрийн Тушаалын Хэргэрэлт №

Аудитаар илрүүлсэн зөрчлийн жагсаалт

Аудитын нэр: Малын эм тарилга, вакцинуулалтанд зориулж улсын тасвас 2016-2017 онд олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүн
Аудитын код: АРА-2018-02-ГА

(сая төг/)

№	Аудитаар илэрсэн Зөрчлийн агуулга	Өгсөн албан шаардлага		Тавьсан акт		Өгсөн зөвлөмжийн тоо	Үр өгөөж	
		Тоо	Дүн /сая төгрөг/	Тоо	Дүн /сая төгрөг/		Тоо	Мөнгөн дүн
1	Баримт материалыг тулган шалгахад анхан шатны баримтын бүрдэл дутуу 10 ажил гүйлгээгээр 38.6 сая төгрөгийг, 2. Аймгийн МЭАлбаны дарга С.Ганбат нь 2017 оны хонины цэцэг өвчний тарилтын үйлчилгээний хөлсөнд 22.0 сая төгрөгийг малын эмч нарт олгосон гэх боловч нотлох баримтгүй, 3. ХХОАТатварын тухай хуулийг зөрчиж тарилтын хөлсөнд 37.2 сая төгрөгийг дундын суутгал хийлгээгүйгээр зарцуулсан, 4. Малын "А" дансны бүртгэл болон малчин өрхийн малын эрүүл мэндийн дэвтрийн бичилтээс илүү тооны малыг тарьсанаар тарилтын цуваанд бүртгэж санхүүжилт авсан,	3	75.8	1	0.5	5	9	76.3
	Нэгдсэн төлөвлөгөөг батлаж хэрэгжүүлээгүй.					3	3	
	1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээнүүдэд аймгийн Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч дүгнэлт гаргасан,	2	39.1				2	39.1
	Нийт дүн	5	114.9	1	0.5	8	14	115.4